# МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 28 өдөр Дугаар А/346 Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлагдсан "Хүн амын хоол тэжээл" үндэсний хөтөлбөрийн 4.3.2, 4.4.2 дугаар заалтыг тус тус үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.14.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Хүүхдэд чиглэсэн хүнсний зар сурталчилгааг зохицуулах удирдамж"-ийг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэхүү удирдамжийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд хамтрагч талуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д. Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/-т даалгасугай.

САЙД Д. САРАНГЭРЭЛ

081395

Эрүүл мэндийн сайдын
2018 оны .08. сарын 28.. өдрийн
А/346 дугаар тушаалын хавсралт

ХҮҮХДЭД ЧИГЛЭСЭН ХҮНСНИЙ ЗАР СУРТАЛЧИЛГААГ
ЗОХИЦУУЛАХ УДИРДАМЖ

**Оршил**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын "Хоол тэжээлээс хамааралт эмгэгийн давхар дарамтыг бууруулах" хөтөлбөр(2015-2020)-ийн хүрээнд дэлхийн болон бүс нутгийн түвшинд хэрэгжүүлж буй хоол тэжээлийн бүхий л арга хэмжээг нэгтгэн хоол тэжээлээс хамааралт эмгэг, хоол тэжээлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглүүлсэн байдаг. Энэхүү хөтөлбөрийн 3 дугаар зорилтод эрүүл хооллолтыг хамгаалах, дэмжих хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, улмаар дэлхийн эрүүл мэндийн 63 дахь чуулган (ДЭМБ, 2010 он)-аар баталсан "Хүнс болон спиртийн агууламжгүй ундааны зүйлсийн хүүхдэд чиглэсэн зар сурталчилгаа"-ны багц удирдамжийг үндэсний түвшинд тохируулан боловсруулах, хэрэгжүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх тухай заасан.

ДЭМБ-аас гишүүн орнуудад хүнсний бүтээгдэхүүний шимт бодисын найрлага, түүнийг харгалзан зар сурталчилгааг зохицуулах бодлого, эрх зүйн баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлж, хүнсний бүтээгдэхүүний "шимт бодисын найрлага"-ыг өөрийн орны нөхцөлд тохируулан ашиглах удирдамж боловсруулсан.

Монгол Улсад 2016-2017 онд зохион байгуулсан хоол тэжээлийн үндэсний V судалгаагаар нийт хүн амын дунд эрүүл бус хоол, хүнсний хэрэглээ түгээмэл, илүүдэл жин ба таргалалтын тархалт 2010 оны түвшингээс эрс нэмэгдсэн байгааг тогтоосон. Тухайлбал, 2010 оны хоол тэжээлийн үндэсний IV судалгааны дүнгээр 15-49 насны эрэгтэйчүүдийн 27.6 илүүдэл жин ба таргалалттай, 5.9 хувь таргалалттай байсан бол 2017 оны байдлаар 48.8 хувь илүүдэл жин ба таргалалттай, 14.6 хувь тарган байгааг ирүүлсэн. Мөн төрөх насны эмэгтэйчүүдийн 32.9 илүүдэл жин ба таргалалттай, 11.1 хувь тарган байсан бол 2017 онд 46.2 хувь ба 16.5 хувь болж тус тус нэмэгдсэн байв. Илүүдэл жин ба таргалалтын тархалт сургуулийн 6-11 насны хүүхдийн дунд 2010 оны түвшин*(Илүүдэл жин ба таргалалттай 7-11 насны хүүхэд–4.3%, таргалалттай–0.6%)*-гээс 7 дахин нэмэгдэж, тэдний 28.6 хувь илүүдэл жин ба таргалалттай, 6.4 хувь тарган байгааг тогтоосон. Сургуулийн хүүхдийн 99 хувь аль нэг төрлийн эрүүл бус хүнс, 97.8 хувь чихэртэй хүнс, 80.9 хувь чихэртэй ундааг тус тус 7 хоногт 1 ба түүнээс олон удаа хэрэглэсэн нь эрүүл бус хоол хүнсний хэрэглээ түгээмэл байгааг илтгэж байна.*(Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал, Үндэсний V судалгааны тайлан, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүүхдийн сан, 2017 он).*

Ийнхүү нийт хүн ам, ялангуяа хүүхдийн дунд түгээмэл тохиолдож байгаа хоол тэжээлээс хамааралт эмгэгийн тархалтыг нэмэгдүүлэхгүй байх, түүнээс үүдэлтэй халдварт бус өвчнөөс сэргийлэх зорилгоор "Хүүхдэд чиглэсэн хүнсний зар сурталчилгааг зохицуулах удирдамж"-ийг батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Танилцуулга**

"Хүүхдэд чиглэсэн хүнсний зар сурталчилгааг зохицуулах удирдамж"-ийн зорилго нь хүүхдийг хоол тэжээлээс хамааралт өвчин, эмгэгээс сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих зорилгоор хүнсний бүтээгдэхүүнийгтүүнд агуулагдах шимт бодисын найрлагыг харгалзан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр ангилж, зар сурталчилгааг зохицуулахад оршино.

ДЭМБ-аас хүнсний бүтээгдэхүүний шимт бодисын найрлагыг түгээмэл зорилгоор ашиглах, ялангуяа хүүхдэд чиглэсэн эрүүл бус хүнсний зар сурталчилгааг хориглох үндсэн шалгуур болгон ашиглахыг зөвлөдөг(WHO. Nutrient profiling).

Хүнсний бүтээгдэхүүнийнайрлагань хүнс, согтууруулах бус ундааны зүйлсийгилчлэг, ханасан тос, транс тос, давс, чихрийн агууламжаар нь эрэмблэн, эрүүл бус хүнснээс эрүүл мэндэд тустай хүнсийг ялган ангилах үндэслэл болно.Хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилалыгхүн амын хооллолтыгбус, хүнсний бүтээгдэхүүнийг эрэмбэлэн ангилахад ашиглана. Гэхдээ нийт хүн амын хооллолт, хүнсний хэрэглээ, тэжээллэг чанарыг сайжруулах бодлогоор хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилалыг ашиглах боломжтой.

"Хүүхдэд чиглэсэн хүнсний зар сурталчилгааг зохицуулах удирдамж"(цаашид Удирдамж гэх)-д ДЭМБ-ынНомхон далайн баруун бүсийн төвийн "Хүнсний бүтээгдэхүүний шимт бодисын найрлагын ангилал"-ыг өөрийн орны нөхцөлд тохируулан ашигласан. Монгол Улсын хүн амын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын эмхэтгэл, хүнсний бүтээгдэхүүнийимпортын дийлэнх хэсгийг бүрдүүлж буй Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Солонгос Улсын хүнсний бүтээгдэхүүний найрлагын хүснэгт болон импортын хүнсний бүтээгдэхүүний шошгын шим тэжээллэг чанарын мэдээллийг ашиглан өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулсан.

Энэхүү удирдамжид хүнсний бүтээгдэхүүнийг түүний шимт бодисын найрлагыг харгалзан 18 бүлэгт хувааж, тэдгээрт агуулагдах нийт тос, нийт чихэр, нэмсэн чихэр, чихэрлэг амт оруулагч (хүнсний нэмэлт), илчлэг, ханасан тос, давсны агууламжийг харгалзан хүүхдэд чиглэсэн зар сурталчилгааг хориглох эсвэл зөвшөөрөх хязгаарыг тогтоосон(Хүснэгт 1).

Удирдамжидхүүхдэд чиглэсэн хүнсний зар сурталчилгааг хориглох 2 төрлийн ерөнхий шаардлагыг тогтоосон.Үүнд.

1. Хүнсний бүтээгдэхүүний нийт илчлэгийн нэгээс их хувь нь үйлдвэрийн аргаар боловсруулсан транс тосны хүчлээс гаралтай байх,
2. Хүнсний бүтээгдэхүүний нийт илчлэгийн 0.5 ба түүнээс их хувийг этилийн спирт бүрдүүлж байвал сурталчлахыг тус тус хориглоно.

"Хүнсний бүтээгдэхүүнийнайрлагын ангилал"-д багтсан (Хүснэгт 1) дараах 3 бүлэг хүнсний бүтээгдэхүүнийг түүнд агуулагдах шимт бодисын хэмжээг үл харгалзан хүүхдэд сурталчлахыг хориглоно. Үүнд:

- Бүлэг 1 – Шоколад ба чихэр, илчлэг ихтэй амттан, чихэртэй түрхлэг, чихэрлэг амттан
- Бүлэг 2 –бялуу, нарийн боов, чихэртэй жигнэмэг, болон бусад төрлийн чихэртэй гурилан бүтээгдэхүүн

- Бүлэг 4с – Эрч хүчний ундаа, цай, кофе

Дээр дурьдсанаас бусад хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгааг хориглоход Хүснэгт 1-д заасан хүнсний найрлага дахь шимт бодисын босго хэмжээг баримтална. Хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилалын Бүлэг 4а(Шүүс)-д заасан босго хэмжээг тогтоохдоо ДЭМБ-ын “Хүүхэд, насанд хүрэгчдийн чихрийн хэрэглээ” удирдамжийг үндэслэсэн болно.

Удирдамжид хүүхдэд чиглэсэн зар сурталчилгааг зөвшөөрөх 2 нөхцлийг тодорхойлсон. Үүнд:

1. Шинэ ба хөлдөөсөнбүх төрлийн жимс (Бүлэг 15-д багтсан)-ийг түүний найрлагыг үл харгалзан сурталчлахыг зөвшөөрнө.
2. Уламжлалт хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгааг үндэсний баяр наадам, тэмдэглэлт өдрүүдэд тодорхой хугацаагаар зөвшөөрнө.

**“Хүнсний бүтээгдэхүүнийнайрлагын ангилал”-ыг ашиглах заавар**

Эрүүл бус хүнс, спиртын агууламжгүй ундааны зүйлсийн хүүхдэд чиглэсэн зар сурталчилгааг хориглоходхүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилалыг ашиглана. Хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилалыг төрийн болон төрийн бус байгууллага, хүнс үйлдвэрлэгч, импортлогч аж ахуйн нэгж ашиглаж болно.

Хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдэд сурталчлахыг зөвшөөрөх эсвэл хориглох эсэхийг тодорхойлохдоо дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Тухайн бүтээгдэхүүн нь хүнсний аль бүлэгт хамаарч байгааг тогтооно.
2. Хүнсэнд агуулагдах шимт бодисын хэмжээг “Хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилал” дахь босго үзүүлэлттэй харьцуулан жишиж үнэлнэ. Хэрэв тухайн бүтээгдэхүүнийг сурталчилж болох бол 100 грамм эсвэл 100 миллилитр хүнсэнд агуулагдах шимт бодисын хэмжээ нь босго үзүүлэлтээс бага байх шаардлагатай.
3. Ресторан, зоогийн газрын бэлэн хоол, түргэн үйлчилгээний эсвэл хүргэлтээр үйлчлэх иж бүрдэл хоол (2–3 төрлийн цэснээс бүрдсэн)–ны найрлага тус бүрийг “Хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилал”-д заасан босго үзүүлэлттэй харьцуулан жишиж,сурталчилах эсвэл хориглох асуудлыг шийдвэрлэнэ.

**“Хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилал”-дашигласан нэр томъёоны тайлбар**

**Нийт тос**гэж хүнсний бүтээгдэхүүний нийт тосны агууламжийг хэлнэ. Нийт тос нь 3 бүлэг тосны хүчил (ханасан, нэг ханаагүй, олон ханаагүй тосны хүчил)-ээс бүрдсэн байж болно.

**Нийт чихэр** гэж хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах моносахар болон дисахарыг хэлнэ.Үүнд сүү, жимс, ногоонд агуулагдах лактоз, галактоз хамаарах бөгөөд хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцад технологийн зориулалтаар нэмж хийсэн болон зөгийн бал, жимсний охь, шүүсэнд агуулагдах энгийн чихэр хамаарна.

**Нэмсэн чихэр** гэж хүнс үйлдвэрлэгч, тогооч эсвэл хэрэглэгчид хоол, хүнсийг боловсруулах, бэлтгэх явцад зориуд нэмсэн моносахар, дисахарыг хэлнэ.Нэмсэн

чихэргэсэн нэр томъёог ашиглахдаа хүнсний найрлагын эмхэтгэл болон бүтээгдэхүүний шошгын шимт бодисын мэдээллийг үндэслэл болгоно. ДЭМБ-ын Зөвлөмжид хүнсэнд зориуд нэмсэн моносахар(глюкоз, фруктоз), дисахар(сахароз буюу элсэн чихэр) болон зөгийн бал, жимсний охь, өтгөрүүлсэн шүүс, шүүсэнд агуулагдах чихрийг "чөлөөт чихэр"-т хамруулсан байдаг. Харин жимс, хүнсний ногоонд агуулагдах моносахар болон дисахар нь "чөлөөт чихэр"-ийн бүлэгт хамаарахгүй.

**Чихэрлэг амт оруулагч**гэж хүнсэнд чихэрлэг амт оруулах зориулалттай хүнсний нэмэлт (моно ба дисахаридаас бусад)-ийг хэлнэ. Технологийн зориулалтаарашигладаг хүнсний нэмэлтийн ангилалд чихэржүүлэгч, хүчтэй чихэржүүлэгч, архины нүүрс уснаас гарган авсан чихэржүүлэгч багтана.Хүнсний бүтээгдэхүүнд чихэрлэг амт оруулахад ашигладаг сахароз (элсэн чихэр), зөгийн бал зэрэг бусад хүнс нь "чихэржүүлэгч"-ийн төрөлд хамаарахгүй.

**Илчлэг** гэж хүнсэнд агуулагдах үндсэн шимт бодис (нүүрс-ус, тос, уураг)-оос ялгарах химийн энергийн нийт хэмжээг хэлнэ.

**Ханасан тос** гэж хүнсэнд агуулагдах ханасан тосны хүчлийг хэлнэ. Энэ бүлэгт хүнсэнд агуулагдах C14, C16, C18 тосны хүчлүүд болон сүү, наргил модны самрын тосны найрлага дахь C4-C18 тосны хүчил багтана.

**Транс тосны хүчил** гэж хоолны үйлдвэрлэл (шарах, жигнэх), үйлчилгээ, худалдааны зорилгоор ургамлын тосыг үйлдвэрийн аргаар устөрөгчжүүлэн гарган авсан тосны хүчлийн транс изомер болох хатуувтар тос (маргарин)-ыг хэлнэ.

**Давс** гэж хүнсэнд агуулагдах натрийг хэлнэ. Нэг грам давс нь 0.4 грамм натритай тэнцэнэ.

**Хүснэгт 1. Хүнсний бүтээгдэхүүний найрлагын ангилал ба зар сурталчилгааг хориглох нөхцөл**

| № | Хүнсний бүлэг | Хүнсний бүлэгт хамаарах бүтээгдэхүүн (жишээ) | Бүлэгт хамаарахгүй хүнс (жишээ) | Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системын дугаар | Хэрэв 100 г бүтээгдэхүүн дэх шимт бодисын агууламж нь дараах босго хэмжээнээс их байвал тухайн хүнсний зар сурталчилгааг хориглоно | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт тос (г) | Ханасан тос (г) | Нийт чихэр(г) | Нэмсэн чихэр (г) | Чихэр-жүүлэгч | Давс (г) | Илчлэг (ккал) |
| 1. | Шоколад, чихэр, чихэртэй түрхлэг, чихэрлэг амттан | • бүх төрлийн шоколад: сүүтэй, хар, цагаан<br>• шоколадтай түрхлэг, өглөөний хоол, мюсли,<br>• бүх төрлийн хатуу чихэр, элсэн чихэр, ёотон, гурилан суурьтай чихэр,<br>• резинэн чихэр,<br>• чихэртэй цэлцэгнүүр<br>• хөөсөн чихэр<br>• газрын самрын түрхлэг,<br>• зөгийн бал<br>• бусад амттан | Шоколадны амттай өглөөний хоол, бялуу, нарийн боов, жигнэмэг, шокаладаар бүрсэн жигнэсэн бүтээгдэхүүн | 04.09<br>17.01<br>17.04<br>18.06<br>Зарим төрөл: 20.06, 19.05<br>Зарим төрөл: 20.08<br>Зарим төрөл: 21.06 | ХОРИГЛОНО | | | | | | |
| 2. | Бялуу, чихэртэй жигнэмэг, нарийн боов, чихэртэй гурилан бүтээгдэхүүн, чихэртэй | • чихэрлэг амттай нарийн боов, хөөмөл боов,<br>• чихэртэй жигнэмэг,<br>• цайны жигнэмэг, | | 19.01.20,<br>19.05.20,<br>19.05.31,<br>19.05.32 | ХОРИГЛОНО | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гурилан бүтээгдэхүүний хуурай бэлдэц | • хөөмөл хайрсан боов – пончик | | | | | | | | | |
| 3. | Амтлаг зууш | • эрдэнэ шиш, эрдэнэшишийн хөөмөл,<br>• самар, холимог самар (хатаасан жимсний хольцтой),<br>• амтлаг жигнэмэг,<br>• нимгэн шаржигнуур жигнэмэг,<br>• цагаан будаа, эрдэнэшиш, улаан буудай, төмсөөр хийсэн бүх төрлийн амтлаг зууш: чипс, шарсан төмс,<br>• тахиа, гахайны махан шарсан зууш | | Зарим төрөл: 02.09<br>Зарим төрөл: 02.10, 08.01, 08.02, 10.05<br>Зарим төрөл: 12.12, 19.04.10, 19.04.20<br>Зарим төрөл: 19.05, 20.05.20, 20.08.11, 20.08.19, 20.08.99 | | | | 0 | | 0.1 | |
| 4. | Ундааны зүйлс | | | | | | | | | | |
| | а. Шүүс | • жимс, ногооны шүүс - 100%,<br>• чихрийн нишингийн шүүс,<br>• өтгөрүүлсэн шүүсийг шингэрүүлж бэлдсэн ундаа,<br>• жимс, жимсгэнийг | Хуурайшуулсан нунтаг шүүс | 20.09 | | | 5 | | 0 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нухаж бэлдсэн шүүс эсвэл сүү нэмж бэлдсэн ундаа | | | | | | | | | |
| | b. Сүүн ундаа | • сүү, чихэржүүлсэн сүү<br>• найруулжбэлдсэн нунтаг сүү,<br>• бүйлс, шар буурцаг, цагаан будаа,овъёосны сүү;<br>• ямааны сүү,<br>• өтгөрүүлсэн сүү,<br>• сүүн холимог (milk shakes)<br>• чихэртэй цөцгий,<br>• уургшуулсан өтгөн сүү | | Зарим төрөл: 04.01,<br>Зарим төрөл: 04.02, 22.02.90 | 4 | | | 0 | 0 | | |
| | c. Эрч хүчний ундаа, цай, кофе | • илчлэг ундаа, цай: хэрэглэхэд бэлэн ба холимог (кофеин агуулсан),<br>• кофе: хэрэглэхэд бэлэн ба холимог | Ургамлын цай | 21.01<br>Зарим төрөл: 22.02 | ХОРИГЛОНО | | | | | | |
| | d. Бусад төрлийн ундаа | • чихэртэй ундаа,<br>• бусад чихэртэйундаа,<br>• амтлаг ус,<br>• найруулсан шоколадтай эсвэл амуу соёлжны нунтагундаа, | Жимс, ногооны 100% шүүс, Сүүн ундаа | Зарим төрөл: 21.06<br>Зарим төрөл: 22.02, | | | | 0 | 0 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | • сироп, эрдэст ус ба / эсвэлламтлаг ус (хийжүүлсэн),<br>• чихэр нэмээгүй наргил модны самрын шинэ шүүс,<br>• нунтаг шүүс | | | | | | | | | |
| 5. | Хөлдөөсөн амттан | • бүх төрлийн зайрмаг<br>• хөлдөөсөн чихэр<br>• хөлдөөсөн жимсний шүүс<br>• хөлдөөсөн тараг, иогурт | | 21.05 | 10 | | 10 | | 0 | 0.2 | |
| 6. | Үр тарианд суурилсан өглөөний хоол | • шоколадтай өглөөний хоол,<br>• мюсли,<br>• хэрэглэхэд бэлэн овъёосны каш | | 19.04.10, 19.04.20 | 10 | | 15 | | 0 | 1.6 | |
| 7. | Тараг, иогурт, сүү, цөцгий болон ижил төрлийн бусад цагаан идээ | • тараг, иогурт<br>• амталсан исгэлэн сүү, цагаан идээ,<br>• бяслагт суурилсан цагаан идээ,<br>• бусад цагаан идээ: айраг, хоормог, аарц, ааруул | Сүү, чихэржүүлсэн сүү | Зарим төрөл: 04.20, 04.30, 04.04;<br>Зарим төрөл: 04.06.10, 19.01.10, 19.01.90;<br>Заримтөрөл:21.06 | 4 | | 10 | | 0 | 0.2 | |
| 8. | Бяслаг | үйлдвэрийн аргаар боловсруулсан бүх төрлийн бяслаг:<br>• хагас хатуу, хатуу бяслаг (чедар),<br>• зөөлөн бяслаг | Монгол бяслаг | 04.06 | 20 | | | | | 1.3 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | (рикота, моцарелла),<br>• зүсмэл бяслаг,<br>• бяслагтай түрхлэг (виола),<br>• нунтаг бяслаг гэх мэт | | | | | | | | | |
| 9. | Хагас боловсруулсан хоол, хүнс, түргэн хоол, холимог хоол | • пицца<br>• лазане<br>• бүх төрлийн сэндвич, бургер<br>• нөөшилсөн шпагеты,<br>• бэлэн гоймон,<br>• хэрэглэхэд бэлэн зутан, агшаамал<br>• нөөшилсөн шош, эрдэнэшиш<br>• жигнэсэн гахайн мах<br>• бууз, банш,<br>• шууд хэрэглэх холимог хоол<br>• бэлэн шөл<br>• шарсан төмс – чипс<br>• цөцгийн тостой шарсан талх (төүст) | | Зарим төрөл: 16;<br>Зарим төрөл: 19.01.20, 19.02.19, 19.01.90;<br>Зарим төрөл: 19.05;<br>Зарим төрөл: 20.05, 21.04; | 10 | 4 | 10 | | | 1.0 | 225 |
| 10 | Цөцгийн тос, бусад төрлийн өөх, тос | • цөцгийн тос,<br>• шар тос,<br>• ургамлын тос,<br>• маргарин,<br>• түрхлэг,<br>• гахайн өөх, тос, | | 02.09<br>04.05<br>15 | | 20 | | 0 | 0 | 1.4 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | • өөхөн тос | | | | | | | | | |
| 11 | Талх, талхан бүтээгдэхүүн, хатаасан талх | • бүх төрлийн талх: цагаан, хар, бүхэл үрийн,<br>• гамбир, хуурай гамбир,<br>• үзэмтэй талх,<br>• шарсан талх - төүст,<br>• бяслагтай талх | Цөцгийн тосонд шарсан талх | 19.01.20<br>10.01.90<br>19.05.10<br>19.05.40<br>19.05.90 | 10 | | 10 | | | 1.2 | |
| 12 | Хатаасан болон шинэ гоймон, паста, цагаан будаа, бусад төрлийн будаа | • хатаасан гоймон<br>• шинэ гоймон | Сүмстэй паста | 10;<br>Зарим төрөл:<br>11<br>19.02 (19.02.20-д хамаарахгүй)<br>19.03 | 10 | | 10 | | | 1.2 | |
| 13 | Шинэ болон хөлдөөсөн бүх төрлийн малын мах, шувуу, загасны мах, бусад махан бүтээгдэхүүн | • цацагт хяруулын сүүл,<br>• шинэ болон хөлдөөсөн бүх төрлийн малын мах, өндөг, тос ихтэй загас (май загас) | | 02 (02.10-д хамаарахгүй);<br>Зарим төрөл:<br>03 (03.05-д хамаарахгүй)<br>16.02 | 20 | | | | | | |
| 14 | Боловсруулсан мал, шувуу, загасны махан бүтээгдэхүүн | • зайдас, хиам,<br>• давсалсан эсвэл лаазалсан малын мах, гахай, загасны махан бүтээгдэхүүн,<br>• бүрж шарсан тахиа, бүрж шарсан загас,<br>• загасны махан бөмбөлөг, | Перони пицца, карритай тахиа | 02.10,<br>Зарим төрөл:<br>03,<br>Зарим төрөл:<br>16 | 20 | | | | | 1.7 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | • үхрийн мах болон тахианы котлет,<br>• элэгний нухаш | | | | | | | | | |
| 15 | Шинэ эсвэл хөлдөөсөн жимс, ногоо, үндэст ургамал | • бүх төрлийн шинэболон хөлдөөсөн жимс, ногоо,<br>• төмс,<br>• шош,<br>• вандуй,<br>• мөөг | | 07.10, 07.11, 07.12, Зарим төрөл: 08(08.01.12-оос бусад 08.01-д хамаарахгүй) 08.02, 08.11, 08.12, 08.13; 08.14 | 20 | | | | | 1.7 | |
| 16 | Боловсруулсан жимс, ногоо, шош | • хатаасан жимс,<br>• хатаасан наргил модны самар,<br>• наргил модны самрын тос,<br>• мармелад,<br>• жимсний чанамал,<br>• лаазалсан жимс, ногоо, шош,<br>• хатаасан мөөг,<br>• нөөшилсөн жимс,<br>• давсалсан, даршилсан ногоо, шош,<br>• мангоны нухаш,<br>• мөөгнөөс гарган авсан мах орлуулагч | Жимсний шүүс | 07.10, 07.11, 07.12, 07.13; 08.01.11 Зарим төрөл: 08.03 Зарим төрөл: 08.05 Зарим төрөл: 08.06; 08.11, 08.12, 08.13, 08.14; 20.01, 20.02, 20.03; 20.04, 20.05, 20.06, 20.07, 20.08.20, 20.08.30, 20.08.40, 20.08.50, 20.08.60, 20.08.70, | 5 | | 10 | 0 | | 1.0 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 20.08.80,<br>20.08.93,<br>20.08.97,<br>20.08.99 | | | | | | | |
| 17 | Шар буурцгаас гарган авсан бүтээгдэхүүн | дүүпүү, түүгээр хийсэн бүтээгдэхүүн (нато – япон үндэсний хоол, tempeh-исгэсэн шар буурцаг) | Цуу, шар буурцгийн тос, шинэ гар буурцаг | Зарим төрөл: 19.01<br>Зарим төрөл: 20.00<br>Зарим төрөл: 21.06 | 12 | | 10 | 0 | | 1.0 | |
| 18 | Сүмс, дүрлэг, салат амтлагч | • кетчуп,<br>• майонез,<br>• салат амтлагч,<br>• цуу,<br>• загасны сүмс,<br>• чихэрлэг халуун сүмс,<br>• шпагети сүмс,<br>• шорлогийн сүмс,<br>• бүх төрлийн амтлагч, | | 21.03 | 10 | | | 0 | | 1.0 | |